



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IY байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-09 № 02157  
Харилцахын хүүг төсөвт төвлөрүүлэх тухай

Газрын тосны газрын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Газрын тосны орлогын харилцахын үлдэгдэлд банкнаас олгосон хүү 615.601.975, Бусад орлогын харилцахын үлдэгдэлд банкнаас олгосон хүү 8.157.747, нийт 623.759.722 (Зургаан зуун хорин гурван сая долоон зуун тавин есөн мянга долоон зуун хорин хоёр ) төгрөгийг "Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгө"-ийн дансанд төвлөрүүлж түүгээрээ зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Газрын тосны тухай хуулийн 9.1-д "гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөрийг улсад төлнө", Монгол Улсын Засгийн газраас газрын тосны хайгуул, олборлолт эрхлэгч компаниудтай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээнд "Гэрээлэгчийн газрын тосны үйл ажиллагаатай холбогдсон татвар, хураамж, төлбөр нь Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн акт болон цаашид батлагдан гарах хууль, эрх зүйн актуудын дагуу зохицуулагдана" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Төлөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих хөрөнгө"-ийн дансанд орлого болгосон 623.759.722 (Зургаан зуун хорин гурван сая долоон зуун тавин есөн мянга долоон зуун хорин хоёр ) төгрөгийг Төрийн сан банкин дахь Үндэсний аудитын газрын Төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нямдорж нарт хариуцуулав.

ТОГТООСОН: АКТЫГ  
 ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын  
 Ахлах аудитор, Ц.Гэрэл  
 УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:  
 Газрын тосны газрын  
 Дарга, Г.Өлзийбүрэн  
 ЭЗСХОХ-ийн дарга С.Нямдорж

070178